



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 06 дугаар сарын 23 өдөр Дугаар 61

Хэрлэн сум

LXI ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 61 дүгээр хуралдаан 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 09:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 100 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Элсэлтийн ерөнхий шалгалт зохион байгуулах бэлтгэл ажлын талаар мэдээлэл танилцуулах,

Боловсрол, соёл урлагийн газар

2.Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалт нэмэгдсэнтэй холбогдуулан иргэдэд нөлөөллийн ажил зохион байгуулах талаар мэдээлэл танилцуулах,

АЗДТГ-ын Олон нийттэй харилцах алба

3.Хөрөнгө гаргах тухай мэдээлэл танилцуулах,

Аймгийн Засаг даргын Тамгын газар

4.Батлагдсан тохиолдлын асуумж, хавьтал тогтоох асуудалд санал танилцуулах,

Тагнуулын газар

5.Политехникийн коллежид нэмэлтээр эмнэлэг дэлгэсэнтэй холбогдуулан гал тогоонд шаардлагатай тоног төхөөрөмжийн тооцоог танилцуулах,

Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар

6.Аж ахуй нэгж байгууллагаас аймгийн Онцгой комисст ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг танилцуулах,


Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн А.Нансалмаа-д:

1.1.Коронавирусын халдвар /Ковид-19/-ын тохиолдол батлагдсан Хан-Уул цогцолбор сургуульд хариуцлага тооцож ажиллах,

1.2.Элсэлтийн ерөнхий шалгалт зохион байгуулахад мөрдөх түр журамд гишүүдийн саналыг тусгаж аймгийн Онцгой комиссын тогтоолоор батлуулах,

/  / М.Бадамсүрэн
/  / Хур Г.Нармандах

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д:

1.3.Коронавируст халдвар /Ковид-19/-ын үед халдвар хамгааллын дэглэм зөрчсөн, хариуцлага алдсан байгууллагуудад хариуцлага тооцох талаар санал танилцуулах,

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын гишүүн Ш.Ёл-д:

1.4.Баяр наадмын үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын хуралдааны шийдвэрээр зөвшөөрсөн тохиолдолд халдварын үед зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулж танилцуулах,

Онцгой комиссын нийт гишүүдэд:

1.5.Долоо хоног бүрийн тогтсон өдөр, цаг товлож тухайн байгууллагад ирүүлсэн санал, хүсэлттэй танилцаж шийдвэрлэх

АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа-д:

1.6.Коронавируст халдвар /Ковид-19/-ын үед Хэрлэн сумын ерөнхий боловсролын сургуулийн эмч нарыг хөлсний гэрээгээр ажиллуулж буй нөхцөл байдлын талаар судалж танилцуулах,

Хоёр.АЗДТГ-ын Олон нийттэй харилцах албаны дарга, Онцгой комиссын гишүүн Э.Батболд-д:

2.1.Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалт нэмэгдсэнтэй холбогдуулан иргэдэд хүргэх нөлөөллийн ажлыг зохион байгуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

2.2.Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалт нэмэгдсэнтэй холбогдуулан иргэдэд хүргэх нөлөөллийн ажлыг зохион байгуулахад шаардагдах зардал 790,000 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас аймгийн Засаг даргын Тамгын газрын Олон нийттэй харилцах албанд олгох,

2.3.Матад сумын малчин Ц.Цэрэнпагмын гэр бүлээс аймгийн Онцгой комисст хандивласан 9 хониноос Халдварын эрсдэлтэй бүс болон Хэрлэн сумын хяналтын цэгүүдэд үүрэг гүйцэтгэж буй албан хаагчдын хоолонд дэмжлэг үзүүлэх зорилгоор 5 толгой хонийг Бүсийн оношилгоо эмчилгээний төвд, 4 толгой хонийг Эрүүл мэндийн газарт Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас олгох,

Гурав.Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзий-д:

3.1.Аймгийн Онцгой комиссын ажилд дайчлагдан ажилласан Засаг даргын Тамгын газрын 00-03 ДОО улсын дугаартай тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээний ажилд шаардлагатай 5,000,000 төгрөгийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх,

 / М.Бадамсүрэн
/ Хур Г.Нармандах

Дөрөв.АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн Э.Эрдэнэбилэг-д:

4.1.Коронавируст халдварын шинжилгээний хариуг цахим системд оруулах “Гэрэгэ пос” төхөөрөмжийг сумын Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвд худалдан авах талаар сумын Засаг дарга, Онцгой комисст хүргүүлэх чиглэлд тусгах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

4.2.Бүртгэл хяналтын системийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын зөвлөх Х.Энх-Отгон ахлан Тагнуулын газар, Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Улсын бүртгэлийн хэлтсийн бүрэлдэхүүнтэй байгуулах тухай аймгийн Онцгой комиссын тогтоол гаргах,

Тав.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

5.1.Сэргэлэн сумын Онцгой комиссоос аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлтийн дагуу Хэрлэн сумын 7 дугаар хяналтын цэгт мал, мах солилцох үйл ажиллагаанд халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж нэвтрүүлэхийг зөвшөөрөв,

5.2.“Мост Ази ГХО” ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн Өвдөг-Баянхошуу хилийн боомтоор БНХАУ-аас тус компанийн ажилчдын хувцас тээвэрлэх тухай хүсэлтийг Улсын Онцгой комисст уламжлахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ
КОМИССЫН ДАРГА  М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ОРЛОГЧ
ДАРГА, ХУРАНДАА  Г.НАРМАНДАХ